



**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ЗАМ ТЭЭВРИЙН САЙД
Н.ТӨМӨРХҮҮ ТАНАА

2015.05.12 № 3/111

Зөрчил арилгуулах тухай

Үндэсний аудитын газрын 2014 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Иргэний нисэхийн ерөнхий газрын 2014 оны санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар Удирдах ажилтнуудын хүүхдүүдийг гадаадад суралцуулахаар 591.2 сая төгрөгийн зардал гаргасан дараах зөрчил давтагдан гарсаар байна. Үүнд:

ИНЕГ-ын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 1.7.5-д их дээд сургууль төгсөгчдөөс, 3,4 дүгээр курст суралцагчдаас, мөн удирдах ажилтнуудын хүүхдүүдийг сонгон шалгаруулалтгүйгээр гадаадад сургаж байгаа нь дээрх журмын 1.7.6-д сонгон шалгаруулалтаар гэж заасныг зөрчсөн байна.

Дотоод журам-ын 2.1.1-д”байгууллагын үндсэн ажилтан байна” мөн түүний харьяа байгууллагад 5-аас доошгүй жил ажилласан байх, 2.2.1-д “урьд өмнө Улсаас буюу байгууллагаас орон сууц авсан, хөнгөлөлт эдэлсэн бол” гэж заасныг тус тус зөрчсөн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах; Төрийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.2-т “ил тод байх,” 4.2.4-т “иргэд хуульд заасан болзол, журмын дагуу адил тэгш байх” гэж заасныг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т: “.....аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

Дээрх зөрчлийг таслан зогсоож холбогдох хууль, зохих журмын дагуу ажиллах;

1. Гадаадад суралцах их дээд сургуульд суралцагчдын “Элсэлтийн сонгон шалгаруулалтын журам”-ыг шинэчлэн ил тод нээлттэй болгох, иргэний нисэхийн тусгай мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх, шалгуур үзүүлэлтийг тогтоох боловсон хүчний нөөц судалгаа гаргах,
2. Ажилтан албан хаагчдад орон сууцны хөнгөлөлт олгох “Хөдөлмөрийн дотоод журам”-ын шалгуурыг тодорхой болгох, шинэчлэн боловсруулах,

3. Улсын Их Хурлын 2013 оны 18 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэлх баримтлах бодлого”-ын баримт бичиг, холбогдох хууль, журмыг мөрдөж ажиллах.
4. Албан шаардлагын биелэлтийг 2015 оны 09 дугаар сарын 30-ны дотор ҮАГ-т ирүүлэхийг Зам тээврийн яамны ТНБДарга Ж.Бат-Эрдэнэ, СЭЗГ-ын дарга Ч.Цэрэнчимэг, ИНЕГ-ын дарга Ц.Эрдэнэбилэг санхүүгийн газрын дарга А.Дагвадорж, нарт хариуцуулав.

Хувийг: Иргэний Нисэхийн Ерөнхий Газарт

АУДИТОР



Ш.ОТГОНБАЯР

